


**“БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ” ОНӨТҮГ-Н
2023 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН**

2023.12.20

Улаанбаатар хот

1.Хөдөө аж ахуйн зориулалттай газрын ашиглалтыг сайжруулж, өрхийн тариаланг нэмэгдүүлэн, хөрс цаг уурын онцлогт тохирсон таримлыг тариалуулж, бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв.Үүнд:



Туршилтын 150 га талбайгаас 10 га талбайд боловсруулж бэлтгэсэн компост бордоо болон бууц цацаж, талбайн хөрсний үргжил шимиийг сайжруулах ажил хийсэн.



Намрын ургац хураалтын ажилд ашиглах бүх тоног тоног төхөөрөмжийн урсгал засварын ажлыг гүйцэтгэсэн.

Байгууллагын тоног төхөөрөмжүүдийг ашиглан иргэдийн захиалгын дагуу газар тариалангийн үйлчилгээ үзүүлэн бууц түрэх ажил хийж гүйцэтгэсэн.

Туршилтын болон хөрс боловсруулалт хийсэн 50 га талбайн 35 га-д овъёос, улаанбуудай тариалж 122 тн ногоон тэжээл, 11 тн өвсөн тэжээл мөн 5 га-с 7 тн ногоон тэжээл тус тус хураан авсан.



2. Сургалтын төв, дадлагын талбай болон засварын төв бүхий "Эрчимжсэн мал аж ахуйн загвар аж ахуй байгуулах зорилтын хүрээнд хийсэн ажлууд:

Энэ онд 16 үнээ тугаллаж, 16 төл хүлээн авсан. Фермийн байнгын үйл ажиллагааг ханган ажиллаж, гэрээт малын эмчид үзүүлэн, урьдчилан сэргийлэх тарилга, вакцинжуулалтад бүрэн хамруулж ариутгал хийлгэсэн. Тайлангийн хугацаанд 7 тонн сүүг бэлтгэн нийлүүлсэн.

Үхрийн зохиомол хээлтүүлгийн техникч" бэлтгэх эрчимжүүлсэн сургалтыг mnGene bank mongolia Малын удмын сангийн үндэсний төв, Нутаг академи ТББ, Удамших хувьсал ХХК Genetic evolution тай хамтран зохион байгуулсан.

Тус сургалтад нийт 10 аймгийн 40 гаруй суралцагч оролцож Нярав, талбайн зохион байгуулагч Б.Дорждээрэм, агрономч Б.Баярцэцэг нар сургалтын сургагч багшаар ажиллан байгууллагын үйл ажиллагаа, дэвшилтэт техник, технологийн талаар болон малын өтөг

бууц, хүнсний био хаягдлыг ашиглан компост бордоо хийж бэлчээр, хадлангийн талбайг бордож, хөрсний үргил шимийг сайжруулж байгаа үр дүнг танилцуулж, зөвлөгөө өгсөн.



Төрөл бүрийн мод тариалах талаар иргэдэд сургалт хийх, зөвлөгөө мэдээлэл өгөх арга хэмжээний хүрээнд байгууллагын веб сайтад мод тарих, арчлах талаар зөвлөмж гарын авлага бэлтгэж оруулсан.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон хот-Иргэний оролцоо” хаврын мод тарих аяны хүрээнд байгууллагын албан хаагчид 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо, “Инчон мөрөөдлийн төгөл”-д 100 ширхэг шар хуайс мод тарив.

2023 оны 10 дугаар сарын 14-ний өдөр “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон хот-Иргэний оролцоо” намрын мод тарих аяны хүрээнд байгууллага хамт олноороо өмнө тарьсан модны арчилгаа, цэнэг усалгаа хийж, шинээр 100 ширхэг мод тарьсан.

Үйл ажиллагаанд оролцохдоо Нийслэлийн байгаль орчны газрын холбогдох мэргэжилтэнүүдээс зөвөлгөө авч хамтран ажилласан болно.





Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны "Мод тарих үндэсний өдөр зарлах тухай" 63, 2021 оны "Засгийн газарт чиглэл өгөх тухай" 58 дугаар зарлигийн хүрээнд Нийслэлийн иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж нэмэгдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хангах, мод тарих соёлыг түгээн дэлгэрүүлэх, олон нийтэд сурталчлан таниулах 2023 оны хаврын улирлын мод тарилтын хүрээнд СХД-ийн 21-р хороо, Нарийны хөндийн Шар хоолойн аманд байрлах өөрийн аж ахуйн талбайд мод арчилгаа, услалтыг хийж шинээр 108 ширхэг Хайлаас модыг тарилаа.



НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ №1 ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГА ЧИГЛЭЛЭЭР:

Байгууллагын албан хаагчдын 2023 оны сургалтын төлөвлөгөөнд 5 арга хэмжээ, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 6 арга хэмжээ төлөвлөж батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан.

“UB.ERP.EDOC” системийн ашиглалт сайжирч, байгууллагын албан хаагч өөрт холбогдолтой албан бичигтэй танилцах, бичгээ цаг тухай бүр нь шийдвэрлэн ажиллаж байна. 2023 оны байдлаар Албан хэрэг хөтлөлтийн erp.ulaanbaatar.mn дэд системийн EDOC системээр дамжуулан 107 албан бичгийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллаж байна.

Албан хаагчдын өргөдөл гомдлыг цаг тухай бурд нь бүртгэн оруулж, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэн ажиллаж байна.

2023 оны байдлаар нийт 7 өргөдөл, хүсэлт хүлээн авч удирдлагад танилцуулан шийдвэрлэх албан тушаалтанд шилжүүлж, хуулийн хугацаанд багтаан бүрэн шийдвэрлэж ажилласан. Нийт ирсэн өргөдөл, гомдлоос шийдвэрлэсэн 7, хугацаа хэтрүүлсэн, өргөдөл буцаасан, шилжүүлсэн өргөдөл гомдол байхгүй байна. Өргөдлийг авч үзвэл 42.86% нь ажилд орох хүсэлтэй холбоотой, 28.57 % нь ажлаас чөлөөлөгдөх тухай, 28.57% нь нийгмийн асуудал шийдвэрлүүлэх хүсэлтэй холбоотой байна.

НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ №2. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ БОЛОН ИЛ ТОД БАЙДЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Байгууллагын <http://www.bmt.ub.gov.mn/> веб хуудсыг тухай бүр шинэчлэн цаг үеийн мэдээ мэдээлэл болон байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг шинэчлэн оруулж, ажлын байрны сул орон тоо гарсан тохиолдолд ажлын байрны зарыг тухай бүр оруулж хэвшсэн. 2023 оны байдлаар цаг үеийн шинжтэй мэдээ мэдээлэл 9, Хүний нөөцтэй холбоотой 8, ил тод байдлын холбоотой тайлан мэдээ 12, Шилэн дансны мэдээлэл 146, үйлчилгээ цэсний сургалт зөвлөгөөний хэсэгт 1 сургалтын гарын авлага бэлтгэж тус тус оруулж, иргэд олон нийтэд мэдээлэл хүргэн ажиллаж байна.

Ажлын байрны сул орон тоо гарсан тохиолдолд байгууллагын веб хуудсанд ажлын байрны зарыг тухай бүр оруулж хэвшсэн.

НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ №3 ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТТЭЙ АЖИЛЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

“UB.ERP” системд тавигдсан өдөр тутмын мэдээг цаг алдалгүй албан хаагчдад хүргэж, системд бүртгэлтэй албан хаагч нар өдөр тутмын мэдээ мэдээлэлтэй танилцаж судалгаанд цаг алдалгүй идэвхитэй оролцож ажиллаж байна.

НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ №4 ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

“Улаанбаатар марафон -2023” олон улсын гүйлтийн тэмцээнд хамт олноороо идэвхитэй оролцож, Нярав, талбайн зохион байгуулагч Б.Дорждэрэм, Хүний нөөц, бичиг хэргийн мэргэжилтэн Д.Отгонмөнх нар 5 км-ийн зайд амжилттай гүйсэн.



Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Сургалт судалгааны төв, Нийслэлийн Архивын газраас зохион байгуулсан сургалтуудад Дарга 4 удаа, Төслийн менежер 3 удаа, Нягтлан бодогч 5 удаа, Агрономч 3 удаа, Хүний нөөц, бичиг хэргийн мэргэжилтэн 4 удаа тус тус хамрагдсан.

НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ №5. ТӨСӨВ САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

2023 оны нийт батлагдсан төсөв 359,8 сая төгрөг үүнээс 2023 онд 345,5 сая төгрөгийн санхүүжилт авч, 14,2 сая төгрөгийг өөрийн орлогоор бүрдүүлсэн байна. Нийт үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл 359,7 сая төгрөг байна.

Газрын даргын 2022 оны өмч эзэмшүүлэх гэрээг дүгнэх шалгалтаар 100 хувь буюу (Бүрэн хангалттай) санал дүгнэлт авсан.

2022 оны Санхүүгийн үйл ажиллагааны тайланд Нийслэл аудит ХХК-аар аудит хийлгэн (Зөрчилгүй) санал дүгнэлт авсан.

2016-2022 оны байгууллагын үйл ажиллагааны хүрээнд Нийслэл дэх Төрийн аудитын газраас Хөдөө аж ахуйн үйл ажиллагааг хамарсан гүйцэтгэлийн аудитын шалгалтад шаардагдах баримт бичгийг бүрдүүлэн өгсөн. Зөрчил дутагдал гараагүй.

Нийслэлийн дотоод аудитын газраас Шилэн дансны хэрэгжилтэнд хяналт хийсэн бөгөөд холбогдох баримт бичгийг бүрдүүлэн өгсөн.

2023 оны Санхүүгийн үйл ажиллагааны тайланд Уваа-Уул ХХК аудитын газраас явцын шалгалт хийсэн бөгөөд шаардагдах баримт бичгийг бүрдүүлэн хүлээлгэн өгсөн.

НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ №6. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийх ажлыг байгууллагын Дарга болон Төслийн менежер хариуцан ажиллаж байна.

НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ №7 АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР:

2023 оны байдлаар байгууллагын хэмжээнд нийт 107 албан бичийг хүлээн авч бүртгэн, удирдлагад танилцуулан, холбогдох мэргэжилтэнд шилжүүлж, шийдвэрлэлтэнд хяналт тавьж ажиллаж байна.

Албан бичгийг **Erp.Edoc** системд бүртгэсэн байдлаар авч үзвэл:

- Системээр бүртгэгдсэн 107
- Байгууллагад нийт ирсэн бичиг 107

Үүнээс:

- Хариутай албан бичиг 35
- Хугацаандаа шийдвэрлэгдсэн 35
- Хариугүй албан бичиг 72
- Хугацаандаа хаасан 70
- Судалж байгаа төлөвтэй албан бичиг 2

Албан бичгийг хугацаа хоцроож шийдвэрлэсэн буюу албан бичгийн шийдвэрлэх хугацааг сунгуулсан албан бичиг байхгүй.

Нийт ирсэн бичгийн шийдвэрлэлийн хувь 100%, албан бичгийн шийдвэрлэлтийн дундаж хоног, ажлын 7 хоногт багтаан шийдвэрлэгдэж, албан бичгийн шийдвэрлэлтийн хяналтын тухай хянан баталгаажуулж байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын хэмжээнд 7 өргөдөл гомдлыг бүртгэн хүлээн авч удирдлагад танилцуулан шийдвэрлэх албан тушаалтанд шилжүүлж, хуулийн хугацаанд багтаан бүрэн шийдвэрлэж ажилласан.

НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ №8 АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР:

Байгууллагын 2023 оны ХХНЖ-ыг батлуулж, 2022 онд байгууллагад үүссэн цаасан суурьтай 70 жил хадгалах 5, байнга хадгалах 38, түр хадгалах 22 баримтыг архивт бүрэн хүлээн авч дууссан.

Үүссэн цаасан болон цахим баримтыг “UB ERP” нэгдсэн системийн “Archive edoc” -д <https://arch.ulaanbaatar.mn/> бүрдүүлэлт хийж, хянан баталгаажуулалт хийсэн.

ХЯНАСАН:
ДАРГА



Н.УУГАНБАЯР

ТАЙЛАН ГАРГАСАН:
ТӨСЛИЙН МЕНЕЖЕР

Ц.ЦОГТГЭРЭЛ